



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.05.02

№ 01/901

УАГ-ГАГ/2013/02-ГА

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ТЭРГҮҮН
ДЭД ДАРГА Ш.СОЛОНГО-д**

Зөрчлийг арилгах арга хэмжээ авах тухай

Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Танай төсвийн багцад 2012 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалтаас 2,681.8 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг дутуу хэрэгжүүлсэн байна. /Хавсралтаар/

Энэ нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 17.1.9-д “Төсөв, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай санхүүжүүлж, биелэлтэд хяналт тавих” гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...” гэж заасныг үндэслэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч дүнг 2013 оны 10 дугаар сарын 1-ний дотор хариу мэдэгдэх албан шаардлагыг хүргүүлж байна.

АХЛАХ АУДИТОР



У.БАЯРМАА

070239